



# МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ТОГТООЛ

2019 оны 7 дугаар  
сарын 3-ны өдөр

Дугаар 274

Улаанбаатар  
хот

Дүрэм, журам батлах тухай


Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 52<sup>1.3</sup>-т заасныг үндэслэн Монгол Улсын Засгийн газраас ТОГТООХ нь:

1. “Худалдан авах ажиллагааны улсын байцаагчийн дүрэм”-ийг 1 дүгээр, “Тендерт оролцох эрхээ хязгаарлуулсан этгээдийн бүртгэлийг хөтлөх журам”-ыг 2 дугаар хавсралт ёсоор тус тус баталсугай.

2. “Ерөнхий байцаагчийн эрх олгох тухай” Засгийн газрын 2018 оны 2 дугаар сарын 28-ны өдрийн 61 дүгээр тогтоолын үндэслэл хэсгийн “Худалдан авах ажиллагааны улсын хяналтын дүрмийн 2.1-д” гэснийг “Худалдан авах ажиллагааны улсын байцаагчийн дүрмийн 3.1-д” гэж, мөн тогтоолын 1 дэх заалтын “худалдан авах ажиллагааны хяналтын” гэснийг “худалдан авах ажиллагааны” гэж тус тус өөрчилсүгэй.

3. Энэ тогтоол гарсантай холбогдуулан “Дүрэм батлах тухай” Засгийн газрын 2015 оны 8 дугаар сарын 3-ны өдрийн 316 дугаар тогтоолыг хүчингүй болсонд тооцсугай.

4. Худалдан авах ажиллагааны улсын байцаагчийн дүрэм, Тендерт оролцох эрхээ хязгаарлуулсан этгээдийн бүртгэлийг хөтлөх журмын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Сангийн сайд Ч.Хүрэлбаатарт үүрэг болгосугай.



Монгол Улсын Ерөнхий сайд

Сангийн сайд

У.ХҮРЭЛСҮХ

Ч.ХҮРЭЛБААТАР